



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар Б/05

Ховд

Албан тушаал бууруулж, ажлаас
чөлөөлөх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.2, 45.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үүрэгт ажлаа хангалтгүй биелүүлсэн, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин нь тухайн албан тушаал эрхлэх шаардлага хангахгүй болсон Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Бадарчийн Бямбажавыг 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөр тасалбар болгон албан тушаал бууруулж, үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Б.Бямбажавын ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.


3. Б.Бямбажавыг зохих ажлын байраар хангах санал боловсруулж танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 07-ны өдрийн
Б/05 дугаар захирамжийн хавсралт



АЖИЛ ХҮЛЭЭЛЦЭХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
дарга)

Гишүүд: Ч.Эрдэнэбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

Ц.Пүрэвсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн Хөдөө аж ахуй
хариуцсан мэргэжилтэн)

Д.Батбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн нягтлан)

Нарийн бичиг: З.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн
сум, байгууллага хариуцсан ахлах
мэргэжилтэн)

-оОо-